



**“ОЮУ ТОЛГОЙН”
ОРОН НУТГИЙН АЖИЛЧДИЙН
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНД
хүсэлт гаргах нь**

2024 оны ... -р сарын өдөр

Миний бие овогтой нь тус ҮЭХ-ны дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч, гишүүнээр элсэж байна. ОЮУ ТОЛГОЙН ОРОН НУТГИЙН АЖИЛЧДИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНД би хуульд заасны дагуу өөрийн цалин хөлсний 1% ба түүнээс дээш хэмжээний татвар болох **40'000** төгрөгийг төлөхийг зөвшөөрч буйгаа үүгээр мэдэгдэж байна.

Энэхүү гишүүний татварыг би 2024 оны сараас эхлэн сар бүр тогтмол:

- ☐ Миний бие өөрөө ҮЭХ-ны дансанд шилжүүлэнэ.
- ☐ Миний цалингаас суутган хорооны дансанд шилжүүлэхийг зөвшөөрч байна.

SAP дугаар: Регистрийн дугаар:

Албан тушаалын нэр:

Газар, хэлтэс:

Утас: Хувийн и-мэйл хаяг:

Гарын үсэг: Огноо:

Үйлдвэрчний эвлэлийн гишүүн нь

Монгол улсын Үндсэн хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, энэ дүрмийн хүрээнд эрх ашгаа нэгдэж хамгаалахыг Оюу Толгой уурхайд хөдөлмөрийн харилцаанд оролцож буй Монгол улсын иргэн, мөн тус улсад хуулийн дагуу оршин сууж хөдөлмөрийн харилцаанд оролцож буй гадаадын иргэн тус ҮЭХ-ны гишүүн байж болно.

- ҮЭ-ийн гишүүнээр элсэх, гишүүнээс татгалзахдаа байгууллагынхаа ҮЭ-ийн хороонд хүсэлтээ бичгээр гаргаж ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлаар уг асуудлыг шийдвэрлэнэ.
- ҮЭ-ийн гишүүнээр элсэж, гишүүний татвараа төлж эхэлснээр ҮЭ-ийн гишүүн болно.
- ҮЭ-ийн хорооны гишүүд нэг загварын батлахтай байна.
- ҮЭ-ийн гишүүн нь өөр салбарын ҮЭ-ийн гишүүн байж үл болно.

Үйлдвэрчний Эвлэлийн гишүүний эрх

- ҮЭ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлого боловсруулахад оролцох, байр сууриа илэрхийлэх.
- ҮЭ-ийн төлөөлөн удирдах байгууллагыг сонгох, тус байгууллагад сонгогдох, нэрээ дэвшүүлэх, татгалзах.
- Үзэл бодол, нэр төр, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, хууль зүйн зөвлөгөө авах, МҮЭ-ийн гэрээт өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх.
- Шаардлагатай үед ҮЭ-ээс хамтын гэрээ, хэлэлцээр бусад дүрэм, журамд заасны дагуу оюун санаа, эд материалын тусламж авах.
- Төрийн болон иргэдийн төлөөлөгчдийн бүх шатны байгууллагад сонгогдох эрхээ эдлэхдээ үйлдвэрчний эвлэлээс хуулийн хүрээнд мөнгөн бус дэмжлэг авах.
- ҮЭ-ийн сургалт, соёл, үйлчилгээ, амралт сувиллаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх.
- ҮЭ-д элсэх, гарах, дахин элсэх.

Үйлдвэрчний Эвлэлийн гишүүний үүрэг

- Хууль ёсыг дээдлэн сахиж, ашиг сонирхлоо хамтран хамгаалах, ҮЭ-ийн эв нэгдлийг бэхжүүлэхийн төлөө идэвхтэй тэмцэх.
- ҮЭ-ийн гишүүний татварыг сар бүр цалин хөлс түүнтэй адилтгах орлогын 1 буюу түүнээс дээш хувиар бэлэн бусаар хураалгаж, ҮЭ-ийн сан хөмрөгийг арвижуулахад идэвх санаачилгатай байх.

- Байгууллагынхаа ҮЭ-ийн хороонд харьяалагдаж ҮЭ-ийн дүрэм, үйл ажиллагааны чиг баримтлал, бодлого шийдвэрийг хамт олондоо сурталчлах, ҮЭ-ийн эгнээг өргөжүүлэхэд оролцох.
- Төр засгийн болон Монголын ҮЭ-ийн бүх шатны байгууллагад нэр дэвшсэн, сонгогдсон, томилогдсон МҮЭ-ийн гишүүн хүмүүсийг дэмжиж ажиллах.
- МҮЭ-ийн холбоо, ҮЭ-ийн хорооноос зохион байгуулсан хурал, уулзалт, ярилцлага, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.